

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 103. | Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх тухай | Дугаар 06 | 370 |
| 104. | Засгийн газрын зарим гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай | Дугаар 07 | 370 |
| 105. | “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 08 | 371 |
| 106. | Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг томилох тухай | Дугаар 09 | 372 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 107. | Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай | Дугаар 17 | 372 |
|------|---|-----------|-----|

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|------------|-----|
| 108. | Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратеги (2011-2015 он) төлөвлөгөө батлах тухай | Дугаар 347 | 373 |
| 109. | Үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай | Дугаар 350 | 379 |
| 110. | Үндэсний хөтөлбөр батлах тухай | Дугаар 359 | 381 |

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

- | | | | |
|------|--|-----------|-----|
| 111. | Засгийн газрын 2007 оны 250 дугаар тогтоолын 3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 01 | 392 |
|------|--|-----------|-----|

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 01 дүгээр
сарын 19-ний өдөр

Дугаар 06

Улаанбаатар
хот

**Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх
Хяналтын зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Агипарын Бакейг Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 01 дүгээр
сарын 20-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар
хот

**Засгийн газрын зарим гишүүнийг
үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39' дүгээр зүйлийн 39'.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дор дурдсан хүмүүсийг Засгийн газрын гишүүн, сайдын үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй:

1/Норовын Алтанхуягийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайдын;

2/Сангажавын Баярцогтыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдын;

3/Лүймэдийн Гансүхийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын;

4/Лувсанвандангийн Болдыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдын;



5/Халтмаагийн Баттулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын;

6/Самбуугийн Ламбааг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдын.

2.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 01 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар
хот

“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын тохируулагч агентлаг” гэсэн хэсэгт “9¹.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, 9².Стандартчилал, хэмжил зүйн газар” гэж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт “12¹.Оюуны өмчийн газар, 12².Улсын бүртгэлийн ерөнхий газар” гэж тус тус нэмсүгэй.

2.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн “Тэргүүн Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд” гэсэн хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2012 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр баталсан Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 01 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дор дурдсан хүмүүсийг Засгийн газрын гишүүн-сайдаар томилсугай:

1/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайдаар Дамдингийн Хаянхярвааг;

2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар Дамдингийн Цогтбаатарыг;

3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайдаар Жадамбын Энхбаярыг;

4/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдаар Цэдэвийн Дашдоржийг;

5/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайдаар Нямдаваагийн Хүрэлбаатарыг.

2.Энэ тогтоолыг 2012 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 3, “Дипломат албаны тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:



Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Тогтохбаярын Батбаатарыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар Түвдэндоржийн Жанабазарыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 12 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 347

Улаанбаатар
хот

**Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратеги
(2011-2015 он) төлөвлөгөө батлах тухай**

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратеги (2011-2015 он) төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод даалгасугай.

3. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжаар хэрэгжих хөтөлбөр, төслийн үйл ажиллагаатай уялдуулан шийдвэрлэж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүрийн 5 дугаар сард тайлагнаж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

М.ЭНХБОЛД



Засгийн газрын 2011 оны 347 дугаар
тогтоолын хавсралт

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫГ БЭХЖҮҮЛЭХ СТРАТЕГИ (2012-2015 ОН) ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Эх үүсвэр	Хугацаа	Хариуцах байгууллага
Зорилт 1. Эрх зүйн орчинг хүүхэд хамгааллын чиглэлээр боловсруулж болгож, олон улсын стандартад нийцүүлэнэ				
Нэг. Удирдлага, санхүүжилтийг бэхжүүлэх				
1.1	Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж, шийдвэрлүүлэх	Хүрэх үр дүн: Хүүхдийн эрхэд тулгуурласан хууль, эрх зүйн орчин бүрдэнэ	2012-2014	НХХЯ, ХТГ, ХЗДХЯ
1.2	Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Иргэний бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиудад хүүхэд хамгааллын асуудлыг нарийвчлан тусгах санал боловсруулах	Улсын төсөв	2012-2015	ХЗДХЯ, НХХЯ, ХТГ
1.3	Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд гэмт хэргийн хохирогч, гэрч хүүхдийн эрхийг хамгаалах талаар нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах	Улсын төсөв	2013-2015	ХЗДХЯ, НХХЯ, ХТГ
1.4	Насанд хүрээгүй хүний эрхийг хамгаалах цоц бодлого боловсруулах, насанд хүрээгүй хүнийг шүүх, байцаах үйл ажиллагаанд шилдэг туршлагыг нэвтрүүлэх	Улсын төсөв	2012-2014	ХТГ, ХЗДХЯ, ХЗҮК
1.5	Хүүхдийн эсрэг бие махбодь, сэтгэл санааны шийтгэлийг бүрэн хориглож, энэ талаар холбогдох мэргэжилтэн болон олон нийт мэдээлэл өгөх үүргийг тодорхой тусгасан эрх зүйн орчин бүрдүүлэх	Улсын төсөв	2012-2013	ХТГ, ХЗДХЯ, ХЗҮК
1.6	Хүүхэд хамгааллын нэр томъёо, ойлголтыг нэгтгэсэн тайлбар гаргаж, олон нийтэд сурталчлах	Улсын төсөв	2012-2014	ХТГ, НХХЯ, ХЗДХЯ
Зорилт 2. Удирдлага, санхүүжилтийг хангах бүтэц, тогтолцоо хангана				
2.1	Хүүхэд хамгааллын асуудлаар зөвшилцөх салбар дундын зохицуулалтыг сайжруулахад Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн үүргийг нэмэгдүүлэх	Улсын төсөв	2012-2015	ХТҮЗ, ХТГ, НҮБХС
2.2	Бүх шатны Засаг дарга, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн дарга нэрт зориулсан хүүхдийн эрх хамгааллын сургалтын модуль гаргаж тэдгээрийг оновчтой хэлбэрээр хамруулах	Улс, орон нутгийн төсөв	2012-2014	ХТҮЗ, ХТГ, аймаг, нийслэлийн Засаг дарга
2.3	УИХ дахь хүүхдийн хөгжил, оролцоо, хамгааллын бүлгийн дэмжлэгээр хүүхэд хамгааллын үйлчилгээ, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах эрх зүйн орчинг шинэчлэх ажлыг эрчимжүүлэх	Улсын төсөв	2012-2015	УИХ-ын Тамгын газар, ХТГ, ХТҮЗ
2.4	Хүүхдийн асуудал харьцсан байгууллагын хүүхэд хамгааллын нэгжийг бэхжүүлж, холбогдох статистик мэдээлэл, судалгаанд түшиглэн тогтмол тайлан илтгэлийг олон нийтэд түгээх	Улс, орон нутгийн төсөв	2012-2013	ХТГ, ХТҮЗ, УСХ, аймаг, нийслэлийн Засаг дарга

2.5	Орон нутагт олон нийтэд түшиглэсэн цогц үйлчилгээний хэлбэрийг дэмжин хөгжүүлэх	Улс, орон нутгийн төсөв	2012-2015	ХТГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ОУБ
2.6	Хүүхэд хамгааллын асуудлаархи зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, байгууллагууд хооронд мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх	Улс, орон нутгийн төсөв	2012-2015	ХТГ, аймаг, нийслэлийн Засаг дарга
2.7	Орон нутагт ажиллаж байгаа хүүхдийн элчид олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэж, улмаар баг, хороонд хүүхдийн элч ажиллуулах боломжийг нэмэгдүүлэх	Улс, орон нутгийн төсөв	2012-2015	ХТГ, ХЭҮК
Зорилт 3	Байгууллагуудын хүлээх үүрэг, оролцоонд тулгуурлан хүүхэдтэй ажилладаг бaш, мэргэжилтэн, ажилтны ёс зүйн харилцааг дээшлүүлнэ	Хүрээ үр дүн: Хамгааллын асуудалд хандах хандлага сайжирсан байна	2012-2014	ХТГ
3.1	Хүүхэд хамгааллын чиглэлээр төрийн захиргааны байгууллагын хүлээх үүргийг ханан үзэж, ажлын үйлдвэр хангах арга хэмжээ авах	Улсын төсөв	2012-2014	ХТГ
3.2	Нийт байгууллагад дагаж мөрдөх хүүхэд хамгааллын бодлого, жишиг дүрмийг гаргаж, хэрэгжилтийг дэмжин ажиллах	Бизнесийн байгууллагын дэмжлэг	2012-2015	ХТГ, ТББ
3.3	Хүүхэд хамгааллын үйлчилгээнд заавал ажиллах сэтгэл зүйч, сэтгэл засалч, согоо зүйч зэрэг мэргэшсэн ажилтанд олгох цалин, урамшууллын асуудлыг судалж шийдвэрлүүлэх	Улсын төсөв	2012	ХТГ, ХХҮГ, ЦЕГ
3.4	Хүүхэдтэй ажилладаг багш, мэргэжилтэн, ажилтны ёс зүйн дүрэм, дагаж мөрдөх журмыг боловсруулж мөрдүүлэх	Улсын төсөв	2012-2013	ХТГ, ТА3, ТББ
3.5	Хүүхэд, гэр бүлд үзүүлэх үйлчилгээнд хамаарах мэдээллийн зохих нууцлалыг хангах	Дотоод нөөц	2013	ХТГ, ЦЕГ, яамд
Зорилт 4. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, үйлчилгээг хөгжүүлэх				
Хоёр. Хүүхэд хамгааллын үйлчилгээ, зохицуулалтыг бэхжүүлэх				
Хүрээ үр дүн: Урьдчилан сэргийлэх үйлчилгээний төрөл баяжин, арга зүй төлөвшсөн байна				
4.1	Хүүхдийг зодож шийтгэдэг эцэг, эх, асран хамгаалагчдын дадал, зан үйлийг өөрчлөн хүүхдээ зөрг аргаар хүмүүжүүлэх мэдлэг чадварыг нэмэгдүүлэх сурталчилгааг нэгдсэн арга зүйгээр дэмжин хэрэгжүүлэх	ОУБ-ын хөгжлийн хөтөлбөр, тусламж	2012-2014	ХТГ, ТББ
4.2	Хүүхэд бүрийг дарамт, хүчирхийлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэх олон нийтийн мэдлэг ухамсрыг нэмэгдүүлэх	Улс, орон нутгийн төсөв, бусад	2012-2015	ХТГ, МАОЭНХ, аймаг, нийслэлийн Засаг дарга
4.3	Эрсдэлээс өөрийгөө, найз нөхдөө хамгаалах мэдлэг, чадварыг олгох хүүхэд зориулсан сургалт, сурталчилгааг боловсролын олон талт хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлэх	Улс, орон нутгийн төсөв	2012-2014	ХТГ, БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга
4.4	Эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдийн суурь хэрэгцээг хангах, эрхийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах, арга хэлбэрийг боловсронгуй болгох	Улсын төсөв	2012-2015	ХТГ, ХТҮЗ



4.5	Сум, хороо, дүүрэгт хүүхдийн зуслан, сувилал, соёл урлаг, биеийн тамир, спортын үйлчилгээг хөгжүүлэх	Орон нутгийн төсөв	2012	аймаг, нийслэлийн Засаг дарга
4.6	Нийтийн эзэмшлийн газарт амралт, чөлөөт цагийн таатай орчин бүхий талбай, парк байгуулан тохижуулах, түүний ашиглалт, хамгаалалтыг сайжруулах	Улс, орон нутгийн төсөв	2013-2014	аймаг, нийслэлийн Засаг дарга
4.7	Хүүхдийн амралт, чөлөөт цагт зориулан арга хэмжээ зохион байгуулах, олон нийтийн оролцоо, санаачилгыг дэмжих	Орон нутгийн төсөв	2012-2015	аймаг, нийслэлийн Засаг дарга
4.8	Онцгой байдлын үед хүүхдийг аврах, хамгаалах аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулж бэлтгэх	Улсын төсөв	2012-2015	ХТГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн Засаг дарга
Зорилт 5. Нөхөн сэргээх үйлчилгээг хөгжүүлнэ				
5.1	Сэтгэл зүй, сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаар зөвлөх, үйлчлэх төвийг дэмжих, нэмэгдүүлэх	Хүрэх үр дүн: Хүүхэд хамгааллын нөхөн сэргээх үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн байна Улсын төсөв, хөгжлийн тусламж	2012-2015	ЭМЯ, НХХЯ, ХТГ, ОУБ
5.2	Хүүхдэд сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх, хэвшсэн сөрөг зан үйлийг өөрчлөх сургалтын хөтөлбөр, арга зүй боловсруулах, хэрэгжүүлэх	Улсын төсөв, хөгжлийн тусламж	2012-2013	ХТГ, ТББ
5.3	Хүүхдэд гэм хор учруулсан иргэн, албан тушаалтныг ойлголт хандлага өөрчлөх сургалт, нөлөөллийн хөтөлбөрт хамруулах ажлыг турших	Улсын төсөв, хөгжлийн тусламж	2012-2015	ХТГ, НЭМХ, ХЗУХ, аймаг, нийслэлийн Засаг дарга
5.4	Хүүхэд хамгааллын үйлчилгээний төрөл, стандарт, удирдамж боловсруулж мөрдүүлэх	Улсын төсөв, хөгжлийн тусламж	2012-2015	НХХЯ, ХТГ, ТББ, аймаг, нийслэлийн Засаг дарга
Зорилт 6. Шуурхай тусламж, үйлчилгээг хөгжүүлнэ				
6.1	Бусдын буруутай үйл ажиллагаанаас амь нас, эрүүл мэндэд нь аюул учирсан хүүхдэд үзүүлэх эмнэлэг түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээг өргөжүүлэх	Хүрэх үр дүн: Шуурхай, найдвартай үйлчилгээ авах боломжтой болсон байна Улс, орон нутгийн төсөв, бусад	2012-2015	ХТГ, НЭМХ, аймаг, нийслэлийн Засаг дарга
6.2	Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах дүрэм, журмыг шинэчлэх	Улсын төсөв	2012-2015	ХТГ, ЦЕГ, ХХУТ, аймаг, нийслэлийн Засаг дарга
6.3	Хүүхэд хамгааллын тусламжийн утасны дуудлагыг үнэ төлбөргүй болгож, үйлчилгээг өргөжүүлэх	Улс, орон нутгийн төсөв, хөгжлийн тусламж	2013-2014	ХТГ, ЦЕГ, аймаг, нийслэлийн Засаг дарга
6.4	Хүүхэд хамгааллын цогц, шуурхай үйлчилгээг сум, дүүрэгт бий болгож, төрийн бус болон хувийн хэвшлийн мэргэшсэн байгууллагыг татан оролцуулах	Улсын төсөв, хөгжлийн тусламж	2012-2015	аймаг, нийслэлийн Засаг дарга, ХТГ
Зорилт 7. Үйлчилгээний зохицуулалт, мэргэжилтний чадавхийг сайжруулна				
		Хүрэх үр дүн: Тусламж, үйлчилгээний дүрэм журам тодорхой болсон байна		

7.1	Хүүхэд хамгааллын үйлчилгээний албан хэргийн бүрдүүлэлтийг сайжруулж, бүртгэл хөглөх маягт, удирдамж, үйлчилгээний заавар, зөвлөмжийг боловсруулж, бүх нэгжид мөрдүүлэх	Улсын төсөв, хөгжлийн тусламж	2012	ХТГ, ХТҮЗ, ТББ, аймаг, нийслэлийн Засаг дарга
7.2	Хүүхдийн эрхийн бодит судалгаа, статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлаар харуу арга хэмжээ төлөвлөх чадавхийг нэмэгдүүлэх	Улсын төсөв, хөгжлийн тусламж	2014-2015	ХТГ, УСХ, аймаг, нийслэлийн Засаг дарга
7.3	Хүүхэд хамгааллын үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх сургалт тогтмол явуулах	Улсын төсөв, хөгжлийн тусламж	2012-2013	ХТГ, ТАЗ
7.4	Анхан шатны нэгжийн мэргэжилтнүүдийг хүүхдийн нэгбүрчилсэн (кейс) үйлчилгээний удирдамж, арга зүйгээр тогтмол хангах	Улсын төсөв, хөгжлийн тусламж	2013-2015	ХТГ, аймаг, нийслэлийн Засаг дарга
7.5	Хүүхэд хамгааллын хамгарсан багийн гишүүдийг чадавхижуулах хөтөлбөр хэрэгжүүлэх	Улсын төсөв, хөгжлийн тусламж	2012-2014	ХТГ, ТББ, ХТҮЗ
Гурав. Орлоогоо хангаж, түншлэлийг бэхжүүлэх				
Зорилт 8. Хүүхэд, хүүхдийн хамт олонд оролцох боломж олгоно				
8.1	Хүүхэд, хүүхдийн хамт олны санал бодлыг сонсох, тэдэнтэй зөвлөлдөх, саналыг нь шийдвэртээ тусгах олон нийтийн санаачилгыг дэмжих, урамшуулах	Улс, орон нутгийн төсөв, хөгжлийн тусламж	2012-2014	ХТГ, ХЭҮК, ХОБУС, аймаг, нийслэлийн ХТХ, ХОНЗ
8.2	Хууль сахиулах байгууллагад хүүхэд бодит байдлыг үнэн зөв мэдээлэх, ярих таатай нөхцөлөөр хангаж, хүүхэд ээлтэй орчин бүрдүүлэх	Улсын төсөв, хөгжлийн тусламж	2012-2015	ХТГ, ХЭҮК, МӨХ, ЦЕГ, ШШГЕГ
8.3	Хүүхдийн оролцоог дэмжих цуврал сургалтын хөтөлбөрт иргэд, олон нийтийг хамруулах хөдөлгөөн өрнүүлж, дүгнэн идэвхжүүлэх	Хөгжлийн тусламж	2012-2014	ХТГ, ТББ, аймаг, нийслэлийн Засаг дарга
8.4	Хүүхэд, хүүхдийн хамт олны байгууллага, хөдөлгөөнийг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх	Хөгжлийн тусламж	2012-2014	ХТГ, БСШУЯ, ТББ, аймаг, нийслэлийн Засаг дарга
8.5	Асран хамгаалах, хяргалах газар байгаа хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх, өргөдөл, гомдол гаргах нөхцөл байдалд хөндлөнгийн хяналт тавих дүрэм, журмыг шинэчлэх	Хөгжлийн тусламж	2012	ХТГ, ХЭҮК, аймаг, нийслэлийн хүүхдийн элч нар
8.6	Хүүхдийн дуу хоолой, үзэл бодлыг нийгэмд сонсох мэдээллийн нээлттэй төвийг тогтмол ажиллах боломж бүрдүүлэх	Улсын төсөв	2012-2015	ХТГ, аймаг, нийслэлийн Засаг дарга
Зорилт 9. Хүүхэд хамгааллын асуудлаар онол, арга зүй, судалгаа-шинжилгээний чадавхийг хөгжүүлнэ				
9.1	Нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр бакалавр, магистрын зэрэг олгох сургалтын хөтөлбөрт хүүхэд хамгааллын сэдвээр хичээл оруулах, цагийг нь нэмэгдүүлэх, окуутны дадлага, судлаачдын эрдэм шинжилгээний ажлыг	Улсын төсөв, хөгжлийн тусламж	2012-2015	ХТГ, БСШУЯ, БХ, ТББ



	дэмжин хөгжүүлэх				
9.2	Хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшүүлэх, гэрчилгээ олгох сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн холбоодын оролцоог нэмэгдүүлэх	Хөгжлийн тусламж	2012-2015	БСШУЯ, ХТГ, ТББ, аймаг, нийслэлийн Засаг дарга	
9.3	Хүүхэд хамгааллын асуудлаар мэргэжилтэн, судлаачийг бэлтгэх, судалгаа шинжилгээ, онол, арга зүйн ном, сурах бичиг, гарын авлага гаргах ажлыг өргөжүүлэх	Хөгжлийн тусламж	2012-2015	ХТГ, ШУА, ТББ, аймаг, нийслэлийн Засаг дарга	
Зорилт 10. Хүүхэд хамгааллын төлөө оролцоо, түншлэлийг хөгжүүлэх					
10.1	Хүүхдийг эрсдэлээс хамгаалахад иргэд, олон нийт, бизнесийн байгууллагатай түншлэлээ өргөжүүлж, оновчтой хэлбэрийг сонгон хамтран ажиллах	Хүрэх үр дүн: Олон нийтийн хандлагатай оролцоо нэмэгдэж, үүргийн давхардал багасна Улс, орон нутгийн төсөв, бусад	2012	ХТГ, аймаг, нийслэлийн Засаг дарга	
10.2	Хүүхдийг хамгаалах үндэсний чадавхийг сайжруулахад олон улсын байгууллагын дэмжлэг авч, зэрэг үр дүнг бэхжүүлэх үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлэх	Хөгжлийн тусламж	2012-2014	ХТГ, ОУБ, аймаг, нийслэлийн ЗДТГ	
10.3	Хүүхэд хамгааллын үйлчилгээнд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог дэмжин, хяналтын тогтолцоог бий болгох	Хөгжлийн тусламж, бусад	2013-2015	ХТГ, ТББ, аймаг, нийслэлийн Засаг дарга	
10.4	Халамж, асрамжийн төвүүдэд хүүхдийг гэр бүл, гэр бүлтэй дүйцэх орчинд асран хамгаалах бодлогын дагуу хөгжүүлж, гэр бүлийг дэмжих, зөвлөгөө өгөх үйлчилгээний арга зүйг түгээх	Улсын төсөв, хөгжлийн тусламж	2012-2015	ХТГ, ХХУГ, аймаг, нийслэлийн ЗДТГ	
10.5	Хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд хамтрагч тапууд гэрээ байгуулан ажиллаж, хүүхдийн аж байдалд гарсан зэрэг өөрчлөлтийг шалгуур болгон гэрээг дүгнэж байх	Хөгжлийн тусламж, төсөв	2012-2013	ХТГ, аймаг, нийслэлийн ЗДТГ	
Зорилт 11. Хэвлэл, мэдээлэлээр дамжуулан нөлөөлөх үйл ажиллагааг дэмжинэ					
11.1	Хэвлэл, мэдээллийн байгууллагын дэмжлэгээр хүүхэд бүрийн аюулгүй байдлыг ханган хамгаалах сурталчилгааг тогтмол явуулах	Хүрэх үр дүн: Олон нийтийн хандлага сайжирсан байна Улсын төсөв, хөгжлийн тусламж	2012-2014	ХТГ, МХХ	
11.2	Хэвлэл, мэдээллийн ажилтан, сэтгүүлчдийн дунд хүүхэд хамгааллын асуудлаар мэргэшэх сонирхлыг дэмжих	Хөгжлийн тусламж	2012-2014	ХТГ, МТХ, аймаг, нийслэлийн ЗДТГ	
11.3	Хүүхэд ээлтэй хэвлэл, мэдээллийн бодлого, хөтөлбөртэй байгууллага, мэргэжилтнийг дэмжин урамшуулах	Улс, орон нутгийн төсөв, бусад	2012-2014	ХТГ, МХХ, МТХ	
11.4	Хүүхэд хамгааллын асуудлаархи тодорхой тохиолдолд тулгуурлан олон нийтийн зэрэг хандлагыг нэмэгдүүлэх нөлөөлөл сурталчилгааг хэвлэл, мэдээлэлээр дамжуулан зохион байгуулах	Улс, орон нутгийн төсөв, хөгжлийн тусламж	2012-2013	ХТГ, МХХ, аймаг, нийслэлийн ЗДТГ	



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 12 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 350

Улаанбаатар
хот

Үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай" Засгийн газрын 2001 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 138 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

Т.ГАНДИ

Засгийн газрын 2011 оны 350 дугаар
тогтоолын хавсралт

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн эрх, үүрэг, түүний удирдлага, зохион байгуулалт, санхүүжилттэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл (цаашид "Үндэсний зөвлөл" гэх) нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг хэрэгжүүлэхэд нийгмийн түншлэгч талуудын оролцоог хангах үүрэг бүхий нийгмийн зөвшилцөлийн байгууллага мөн.

Хоёр. Үндэсний зөвлөлийн эрх, үүрэг

2.1. Үндэсний зөвлөл нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.8-д зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:



2.1.1. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажиллах хүч гадаадад гаргах хууль тогтоомж, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавихад төрийн захиргааны байгууллагад дэмжлэг үзүүлэх;

2.1.2 хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих;

2.1.3. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд нийгмийн түншлэлийг хөгжүүлэх, иргэд, төрийн бус байгууллагын оролцоог идэвхжүүлэх;

2.1.4. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг мэргэжлийн боловсрол, сургалтын, нийгмийн даатгалын зэрэг үндэсний бусад зөвлөл, мэргэжлийн холбоодын ажилтай уялдуулах;

2.1.5. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс гаргасан үүсгэл санаачилгыг дэмжиж, хамтран ажиллахад нь туслалцаа үзүүлэх;

2.1.6. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд Олон улсын хөдөлмөрийн байгууллага болон гадаад орны холбогдох байгууллагатай хамтран ажиллах.

Гурав. Үндэсний зөвлөлийн удирдлага,
зохион байгуулалт

3.1. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд хуралдааныг гишүүдийн дийлэнх олонхи (бүрэлдэхүүний 75-аас доошгүй хувь) нь оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно. Хуралдааны шийдвэрийг хуралдаанд оролцсон гишүүд зөвшилцөн гаргаж зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

3.2. Үндэсний зөвлөлийн шийдвэрийг аймаг, нийслэл, дүүргийн салбар зөвлөл, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны бүх шатны байгууллага хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.3. Үндэсний зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Хуралдааныг зөвлөлийн дарга, түүний эзгүйд орлогч дарга зарлан хуралдуулах бөгөөд шаардлагатай үед аль нэг талын санаачилгаар ээлжит бус хуралдааныг хийж болно.

3.4. Үндэсний зөвлөлийн хуралдаанаас эрх, үүргийнхээ хүрээнд санал дүгнэлт, зөвлөмж, тогтоол гаргах бөгөөд хуралдааны явцыг тэмдэглэлд тусгаж баталгаажуулна.



3.5. Үндэсний зөвлөл нь аймаг, нийслэл, дүүргийн салбар зөвлөлийг байгуулж түүний үйл ажиллагааны дүрмийг баталж мөрдүүлнэ.

3.6. Үндэсний зөвлөл нь тогтоосон журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж Төрийн санд харилцах данстай байна. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

3.7. Үндэсний зөвлөлийн ажлын албаны үүргийг хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ. Үндэсний зөвлөлийн ажлын албаны нарийн бичгийн дарга нь хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудлыг хариуцсан ажилтан байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 12 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 359

Улаанбаатар
хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.1.3-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Эрүүл хот, дүүрэг, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох үндэсний хөтөлбөр”-ийг 1 дүгээр, хөтөлбөрийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. “Эрүүл хот, дүүрэг, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашчулуун)-нд даалгасугай.

3. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг өөрийн эрхлэх ажлын хүрээнд хэрэгжүүлж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусгахын зэрэгцээ гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Сангийн сайд С.Баярцогт, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа,



Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт нарт үүрэг болгосугай.

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэн жил бүрийн II улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЛАМБАА

Засгийн газрын 2011 оны 359 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ЭРҮҮЛ ХОТ, ДҮҮРЭГ, СУМ, БАГ, АЖЛЫН БАЙР, СУРГУУЛЬ
БИЙ БОЛГОХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР (2012-2016)**

Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Монгол Улсын нийгэм-эдийн засаг, техник, технологийн хурдацтай хөгжилтэй холбогдон хот, суурин газрын хөгжил, хүн амын эрүүл мэндийн байдалд ахиц, өөрчлөлт гарч байгаа боловч хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, хотжилт, хүрээлэн байгаа орчны бохирдол, иргэдийн эрүүл бус дадал хэвшил, буруу зан үйл зэрэг нягт холбоотой олон хүчин зүйлс хүний эрүүл мэнд, сэтгэлзүйн байдалд сөргөөр нөлөөлж, нийгэм, эдийн засагт хохирол учруулсаар байна.

Хот, хөдөөгийн хөгжлийн болон амьдралын түвшний ялгаатай байдлаас үүдэлтэй хот, суурин газрыг чиглэсэн шилжилт хөдөлгөөн хурдасч, энэ төвлөрөл нь хот төлөвлөлт, дэд бүтэц, эрүүл мэнд, орон сууц, тээврийн үйлчилгээ, ус хангамж, хог хаягдлын аюулгүйн менежментэд сөргөөр нөлөөлж, нийтийн үйлчилгээг хүрэлцээ муутай болгон гэр хороололд оршин суугчдын тоог эрс нэмэгдүүлсээр байна.

Эрүүл ахуйн шаардлага хангасан ундны ус, хүнсээр хүрэлцээтэй хангагдаж чадахгүй, халуун усны газар хангалтгүй, сургуулийн хүүхдийн гар угаах, бие засах газар орчин үеийн шаардлагыг хангаагүй, сумын



эмнэлгүүдэд нийгмийн эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа хангалтгүй хийгдэх зэрэг олон тулгамдсан асуудал байсаар байна.

Иймд хотжилт, төвлөрлөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, эрүүл хот, дүүрэг, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох, салбар хоорондын хамтын ажиллагаа, энэ ажилд хамт олны оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харгалзан “Эрүүл хот, дүүрэг, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох үндэсний хөтөлбөр”-ийг (цаашид “хөтөлбөр” гэнэ) боловсруулсан болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1 Иргэд, хамт олон, салбар хоорондын болон олон нийтийн хамтын ажиллагаа, идэвхтэй оролцоог дэмжиж, эрүүл, аюулгүй амьдрах, сурч боловсрох, хүмүүжих, ажиллах орчинг бүрдүүлж эрүүл зан үйлийг төлөвшүүлэх замаар хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2 Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилтыг дэвшүүлж байна:

2.2.1. хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа орчны бохирдол доройтлыг бууруулсан, эрүүл, аюулгүй амьдрах таатай нөхцөл бүрдүүлсэн хот төлөвлөлт, дэд бүтэц болон хамт олон, салбар хоорондын хамтын ажиллагаа, идэвхтэй оролцоог дэмжиж, эрүүл зан үйл хэвшсэн хотын орчинг бүрдүүлнэ;

2.2.2. салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлан иргэнд ээлтэй төлөвлөлт, тохижилт бүхий хүн амын эрүүл зан үйлийг төлөвшүүлсэн дүүргийн орчинг бүрдүүлнэ;

2.2.3. айл өрх, албан байгууллагын ариун цэвэр, эрүүл ахуй, амьдралын нөхцөлийг дээшлүүлсэн, ундны усны найдвартай эх үүсвэртэй, хүнсний аюулгүй байдлыг хангасан, оршин суугчдад нийгэм сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлсэн сум, багийн орчинг бүрдүүлнэ;

2.2.4. хамт олны болон хувь хүний эрүүл зан үйлийг төлөвшүүлсэн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын байрыг бий болгоно;

2.2.5. хүүхэд, суралцагч, багш, ажилтнуудын эрүүл аюулгүй орчинд сурч хөгжих, ажиллах сэтгэл зүйн болон материаллаг орчин, нөхцлийг бүрдүүлж, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх замаар эрүүл мэндийг дэмжигч сургууль, цэцэрлэгийг хөгжүүлнэ.



Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

3.1.1. хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа, холбоонд тулгуурлах;

3.1.2. ДЭМБ болон олон улсын чиг хандлага, удирдамжид түшиглэсэн байх;

3.1.3. нийгмийн түншүүд, иргэний нийгмийн болон олон улсын байгууллагын хамтын ажиллагаанд түшиглэх.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн

4.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1. хот төлөвлөлт, экологи, эрүүл мэндийн талаархи хууль тогтоомж, стандарт, норм, дүрэм, журмыг боловсронгуй болгох;

4.1.2. хотын орчны таатай нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байгаа байгууллага, дотоодын болон олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, эрдэм шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн мэдээллийн сантай болгох;

4.1.3. ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу хотын барилгажилт, дэд бүтцийг орчин үеийн барилгын дэвшилтэт технологиор барьж байгуулах, барилга байгууламжийг барих үеийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг хангуулах;

4.1.4. хот суурин газарт үерийн хамгаалалтын далан, суваг, инженерийн барилга байгууламжийг өргөжүүлэх;

4.1.5. хотын гэр хорооллын цахилгаан холболтыг хүрэлцэхүйц болгох;

4.1.6. хотын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох;

4.1.7. хотын хаягдал усыг дахин ашиглах нөхцөлийг хот, дүүргийн хэсэгчилсэн, ерөнхий төлөвлөгөөг батлахдаа тусгаж байх;



4.1.8. хотод орчин үеийн шаардлага хангасан халуун усны газар, нийтийн бие засах газрын тоог нэмэгдүүлэх;

4.1.9. хот, суурин газрын гэр хорооллын айл өрхийг цэвэр түлшээр хангах;

4.1.10. хотын хөрс, ус, агаарын химийн бодисын бохирдол болон дуу шуугианыг багасгах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;

4.1.11. хотын нийтийн тээврийг дэмжих;

4.1.12. нийгмийн амгалан байдлыг хангах, хүчирхийлэл, гэмт хэрэгтэй тэмцэх, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх.

Хүрэх үр дүн: Хотын аюулгүй, эрүүл орчинг бүрдүүлэх хууль эрх зүйн болон бодлогын баримт бичиг шинэчлэгдэж, салбар хоорондын үйл ажиллагаа, зохицуулалт сайжирч, нэгдсэн мэдээллийн тогтолцоонд тулгуурласан хотын эрүүл, аюулгүй нийгмийн орчин бүрдэнэ.

4.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1. орон нутгийн онцлог, тулгамдсан асуудалд тулгуурлан “Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, салбар хоорондын болон байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;

4.2.2. дүүргийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, техник, технологийн шинэчлэлт хийх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгжийг өргөнөөр татан оролцуулах арга механизмыг бий болгох;

4.2.3. дүүргийн гэр хорооллыг усан хангамж, ариутгах татуургын нэгдсэн системд үе шаттай холбох, холбогдоогүй айл өрхийг эрүүл ахуйн шаардлага хангасан бие засах газар, бохир усны цооногтой болгох;

4.2.4. оршин суугчдын болон албан байгууллагын гаднах талбайн тохижилтыг сайжруулж цэцэрлэгжүүлэх, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх;

4.2.5. айл, өрхөд ундны цэвэр ус түгээх худагт засвар, үйлчилгээ хийх, худгийн тоог нэмэгдүүлэх;



4.2.6. төв, суурингийн айл өрхөд усалгаатай, хучлагатай талбай, хүлэмж, бий болгож төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах нөхцөлийг бүрдүүлэх;

4.2.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хотын тохижилтыг бий болгох;

4.2.8. эрүүл, аюулгүй, цэвэр орчныг бий болгох хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх;

4.2.9. хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зах, худалдааны цэгүүдийн эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөлийг сайжруулах.

Хүрэх үр дүн: Дүүргийг хөгжүүлэхэд иргэд, олон нийт, салбар хоорондын оролцоо сайжирч эрүүл, аюулгүй орчин бүхий тохижилттой дүүрэг бий болно.

4.3 Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1. “Эрүүл сум, баг” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагаа, оролцоог нэмэгдүүлэх;

4.3.2. баталгаат усны эх үүсвэрээс ундны ус түгээлтийг хийж чанарын баталгаатай усаар сум, багийн хүн амыг хангах;

4.3.3. сум, багийн хүн амын ундны усны эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтоох, хамгаалалт барих, бохирдолтоос хамгаалах арга хэмжээ авах;

4.3.4. сум, багт халуун усны газрыг бий болгох, тоог нэмэгдүүлэх;

4.3.5. сум, багийн түвшинд хатуу, шингэн болон халдвартай хог хаягдлыг аюулгүй устгах төлөвлөгөөтэй болох;

4.3.6. нийгмийн амгалан байдлыг хангах, хүчирхийлэл, гэмт хэрэгтэй тэмцэх, зам тээврийн осол гэмтлээс сэргийлэх, урьдчилан сэргийлэх, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах;

4.3.7. иргэдэд эрүүл аж төрөх дадал, эрүүл зан үйл төлөвшүүлэх чиглэлээр сум, багийн нийгмийн эрүүл мэндийн төвийг чадавхижуулах, оролцоог нэмэгдүүлэх.



Хүрэх үр дүн: Сум, багийн түвшинд ундны найдвартай эх үүсвэртэй болж, хог хаягдлыг устгах төлөвлөгөөг хэрэгжүүлж, иргэдэд эрүүл, аюулгүй амьдрах орчин бүрдэнэ.

4.4. Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. байгууллагууд "Эрүүл ажлын байр" бий болгох хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

4.4.2. байгууллагын онцлог, соёлд тулгуурлан хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны стандартад нийцүүлэн ажлын байрыг тохижуулах;

4.4.3. ажиллагчдыг чанарын шаардлага хангасан өдрийн хоол, хүнс, ундны усаар хангах;

4.4.4. ажиллагчдыг шаардлага хангасан бие засах газар, гар угаагуураар хүрэлцээтэй хангах;

4.4.5. үйлдвэрлэлийн осол, хордлого, халдвар, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн норм, дүрмийг чанд мөрдүүлэх;

4.4.6. байгалийн болон болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх талаар байгууллагаас авах арга хэмжээг төлөвлөн, бэлэн байдлыг хангуулах;

4.4.7. архи тамхигүй хамт олон бий болгох, идэвхтэй хөдөлгөөн, зохистой хооллолтыг дэмжсэн орчин бүдүүлэх;

4.4.8. эрүүл ажлын байрыг хөгжүүлэхэд хамт олны оролцоог нэмэгдүүлэх, хувь хүн, хамт олонд эрүүл зан үйл төлөвшүүлэх, эрүүл аж төрөх, эрүүл амьдралын хэв маяг хэвшүүлэх, мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг тогтмолжуулах;

4.4.9. ажилчдад эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх нөхцөлөөр хангах.

Хүрэх үр дүн: Ажилчдын сэтгэлзүйн болон биеийн эрүүл мэндийг хамгаалсан, аюулгүй, эрүүл орчин бүрдсэнээр хөдөлмөрийн бүтээмж өндөр ажиллах хүчний тоо нэмэгдэнэ.

4.5. Хөтөлбөрийн 5 дугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



4.5.1. эрүүл мэндийг дэмжигч сургууль, цэцэрлэг болох зорилтыг сургууль, цэцэрлэгийн хэтийн болон дунд хугацааны ажлын төлөвлөгөөнд оруулж хэрэгжүүлэх;

4.5.2. ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадаад, дотоод орчныг тохижуулан, аюулгүй, эрүүл орчинд сурах, хөгжих, алжаал тайлах, амрах нөхцөл бүрдүүлэх;

4.5.3. сургууль, цэцэрлэгт бие засах өрөө, гар угаалтуурын тоог стандартын хэмжээнд хүргэх;

4.5.4. сургуулиудад “Үдийн цай”, “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх аюулгүй, тав тухтай орчинг бүрдүүлэх;

4.5.5. эрүүл мэндийн зан үйлийн эерэг өөрчлөлтийг дэмжих, урамшуулах, хамт олон болон олон нийтэд сурталчлах үйл ажиллагааг тогтмол явуулж хэвших;

4.5.6. сургууль, цэцэрлэгт тамхигүй орчинг бүрдүүлэх, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг тогтмол сурталчлах;

4.5.7. суралцагч болон багш, ажиллагсдын эрүүл мэнд, бие бялдрын чийрэгжилтийн түвшинг жил бүр тогтоож, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран урьдчилан сэргийлэх үзлэг хийх, үзлэгийн мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

4.5.8. эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа, мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээг өрхийн эрүүл мэндийн төвд түшиглэн явуулах нөхцөлийг бүрдүүлэх.

Хүрэх үр дүн: Хүүхэд, суралцагч, багш, ажилтнуудын эрүүл, аюулгүй орчинд сурч ажиллах таатай орчныг бүрдүүлсэн сургууль, цэцэрлэгийн тоо нэмэгдсэн байна.

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

5.1. Хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, салбар дундын асуудлыг зохицуулах үүргийг орон тооны бус Удирдах зөвлөл гүйцэтгэнэ.

5.2 Хөтөлбөрийг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулна.



5.3. Удирдах зөвлөлийн ажлын албаны үүргийг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ. Удирдах зөвлөлийн ажлын албаны нарийн бичгийн даргын үүргийг Эрүүл мэндийн яамны “Эрүүл хот” хөтөлбөрийн үндэсний зохицуулагч гүйцэтгэнэ.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

6.1.1. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

6.1.2. гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

6.1.3. олон улсын байгууллага, хандивлагч орны төсөл, зээл, тусламж болон төсөв, хөтөлбөрийн санхүүжилт;

6.1.4. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Долоо. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, шалгуур үзүүлэлт

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран гүйцэтгэнэ.

7.2. Хөтөлбөрийн үр дүнг дүгнэхдээ 2011 оны жилийн эцсийн үзүүлэлтүүдийг суурь үзүүлэлт болгон ашиглах бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

7.3. Шалгуур үзүүлэлт:

№	Үзүүлэлт	2010 оны суурь түвшин (хувиар)	2016 онд хүрэх түвшин (хувиар)	Мэдээний эх үүсвэр
Эрүүл хот				
1	Гэрийн хорооллын хүн амын ундны ус түгээх хугдгийн тоо	549	700	НЗДТГ
2	Сайжруулсан ариун цэврийн байгууламж хэрэглэж байгаа хүн амын эзлэх хувь	41	51	НЗДТГ



3	Гэмт хэргийн гаралтын тоо, үүнээс нас барсан хүний тоо	10863/665	Буурсан байна	НЗДТГ
4	Хотын ногоон байгууламжийн талбай	1925га	Нэмэгдсэн байна	НЗДТГ, БОАЖЯ
5	Хотын тамхигүй орчин бүрдүүлсэн рестораны тоо	5	Нэмэгдсэн байна	НЗДТГ, НЭМГ
Эрүүл дүүрэг				
1	Дүүргийн гэр хорооллын цэвэр усны хэсгийн системд холбогдсон: -өрхийн тоо -байгууллагын тоо Үүнээс бохир усны системд холбогдсон: -өрхийн тоо -байгууллагын тоо	159 167 86 26	Нэмэгдсэн байна	НЗДТГ НЭМГ
2	Дүүргийн орон сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь	38,2	Нэмэгдсэн байна	НЗДТГ, НЭМГ, ҮСХ
3	Дүүрэгт баригдсан орчин үеийн шаардлагад нийцсэн нийтийн бие засах газрын тоо	16	20	НЗДТГ, НЭМГ
Эрүүл сум, баг				
1	Ундны ус түгээх байрны тоо	30	Нэмэгдсэн байна	МХЕГ, УГ
2	Усны чанар сайжруулах тоног төхөөрөмж суурилуулсан сумын тоо	50	Нэмэгдсэн байна	МХЕГ, УГ
Эрүүл ажлын байр				
1	Үйлдвэрлэлийн осол гэмтлийн тоо, үүнээс нас барсан хүний тоо	32	Буурсан байна	НЭМГ, ЭМГ
2	Тамхигүй орчин бүрдүүлсэн албан байгууллагын тоо	4	Нэмэгдсэн байна	НЭМГ, ЭМГ
3	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо	14	Нэмэгдсэн байна	НЭМГ, ЭМГ
Эрүүл сургууль				
1	Эрүүл мэндийг дэмжигч ерөнхий боловсролын сургуулийн эзлэх хувь	3.6%	20%	НЭМГ, БСШУЯ
2	Стандартын шаардлага хангасан бие засах газартай сургууль, цэцэрлэгийн хувь	11.8%	30%	БСШУЯ



Засгийн газрын 2011 оны 359 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

**“ЭРҮҮЛ ХОТ, ДҮҮРЭГ, СУМ, БАГ, СУРГУУЛЬ БИЙ
БОЛГОХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга	-Монгол Улсын Шадар сайд
Орлогч дарга	-Эрүүл мэндийн сайд
Гишүүд:	-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч;
	-Дархан-Уул аймгийн Засаг дарга;
	-Дорноговь аймгийн Засаг дарга;
	-Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга;
	-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга;
	-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга;
	-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;



**Нарийн бичгийн
дарга**

-Баянзүрх дүүргийн Засаг дарга;

-Сүхбаатар дүүргийн Засаг дарга;

-Монголын Хотуудын холбооны тэргүүн (зөвшилцсөнөөр);

-Монголын Эрүүл Хотуудын холбооны тэргүүн (зөвшилцсөнөөр).

-Эрүүл мэндийн яамны “Эрүүл хот” хөтөлбөрийн үндэсний зохицуулагч.

— МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ —

2012 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Засгийн газрын 2007 оны 250 дугаар тогтоолын 3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 12.45 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга Н.Жанцан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат /илтгэгч/, Д.Наранчимэг, Д.Мөнхгэрэл, Б.Пүрэвням нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Н.Болортунгалагийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Н.Улам-Ундрахын итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.Сурахбаяр, өмгөөлөгч Б.Цэцэнбилэг, Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын дэд сайд А.Гансүх нар оролцов.



Хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 250 дугаар тогтоолын 3-т “Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад орон сууц барих зориулалтаар газар олгох, гэрээ байгуулахдаа барих орон сууцны 2.0 хувийг үнэ төлбөргүйгээр, 20.0 хүртэл хувийг өөрийн өртгөөр нь тооцож тусгай санд шилжүүлэх...” гэж заасан нь Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэв.

Нэг. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны оршин суугч, иргэн Нямсүрэнгийн Улам-Ундрах Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн мэдээлэлдээ:

“...Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн “Ахмад дайчдын орон сууцны тухай” 250 дугаар тогтоолын 3 дахь заалтад “Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад орон сууц барих зориулалтаар газар олгох, гэрээ байгуулахдаа барих орон сууцны 2.0 хувийг үнэ төлбөргүйгээр, 20.0 хүртэл хувийг өөрийн өртгөөр нь тооцож тусгай санд шилжүүлэх...”-ээр заасан нь Засгийн газар Үндсэн хуулиар олгогдсон “салбар ба салбар хоорондын, түүнчлэн бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх” онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд нийгэм, эдийн засгийн үйл ажиллагааг зохицуулсан шийдвэр гаргах эрх бүхий байгууллага хэдий ч гарч байгаа шийдвэр нь Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн байх шаардлагатай билээ. Энэ нь Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах...” гэснийг зөрчиж байна.

Газрын тухай хууль болон Газрын тухай хуульд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжуудад газар эзэмших эрх олгохдоо бусдын өмчлөлийн зүйлийг авах талаар ямар нэгэн зохицуулсан эрх зүйн акт байхгүй билээ. Иймээс Засгийн газар дээрх тогтоолыг гаргасан нь Үндсэн хуулийн энэхүү заалтыг зөрчиж байна гэж үзэх үндэслэл болж байна...

...Газрын тухай хуульд газар эзэмших, ашиглах эрхийг иргэн аж ахуйн нэгж байгууллагад олгох журмыг хуульчилсан байдаг бөгөөд энэхүү хуульд уг газрыг ашиглахад ашиглаж байгаа этгээдийн хөрөнгөөс үнэ төлбөргүй гаргуулах талаар зохицуулалт байхгүй билээ. Гэтэл Засгийн газар тогтоол гаргахдаа ямар нэгэн хуульд үндэслэлгүйгээр эрх хэмжээгээ хэтрүүлэн гаргасан байна. Иймд хууль зүйн үндэслэлгүй 2007 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн “Ахмад дайчдын орон сууцны тухай” тогтоол нь Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.” гэжээ.



Хоёр. Иргэн Н.Улам-Ундрах Үндсэн хуулийн цэцэд дахин хандаж гаргасан гомдолдоо:

“...Засгийн газар бодлого хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн гаргах ёстой юм. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “...Засгийн газар нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон тогтоол гаргахдаа тусгайлан эрх олгосон хуулийг иш үндэс болгоно...” гэж заасан байдаг. Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 250 дугаар тогтоол нь тодорхой хэм хэмжээ тогтоосон байх бөгөөд үүнийг нийтээр даган мөрдөх шинжтэй акт байна.

Гэтэл уг тогтоол нь хуульд тусгайлан эрх олгосон заалт байхгүй мөн хуулиар зохицуулаагүй зүйлийг Засгийн газар өөрөө тогтоосон нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэгт зааснаар “Үндсэн хууль, бусад хуулийг биелүүлэх зорилгоор тогтоол, захирамж гаргаж биелэлтийг хангана.” гэж заасныг зөрчиж байгаа бөгөөд энэ нь Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах...” гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэл болж байгаа юм.

...Барилга байгууламж барьж байгаа явдал нь газрыг тодорхой нэг зориулалтаар эзэмшиж байгаа үйл явц бөгөөд уг үл хөдлөх хөрөнгө нь газар эзэмшигчийн өмч юм. Газар эзэмшигч нь газар эзэмшиж байгаагийн хувьд газрын төлбөрийг хууль тогтоомжид заасан хэмжээгээр төлдөг. Үүн дээр хуульд заагаагүй нөхцөлөөр Засгийн газар өөрөө хэм хэмжээ тогтоон хувийн өмчийг үнэ төлбөргүй авч байгаа нь хууль бус гэж үзэж байна...” гэжээ.

Гурав. Монгол Улсын Ерөнхий сайдын 2011 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 79 дүгээр захирамжаар томилогдсон Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгч, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын дэд сайд А.Гансүх Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Үндсэн хуулийн цэцийн 2011 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 13 дугаар магадлалаар иргэн Н.Улам-Ундрахын өргөдлийг хянан хэлэлцэж, гомдлын зарим шаардлага буюу Засгийн газрын 2007 оны “Ахмад дайчдын орон сууцны тухай” 250 дугаар тогтоолын 3-т “Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад орон сууц барих зориулалтаар газар олгох гэрээ байгуулахдаа барих орон сууцны 2.0 хувийг үнэ төлбөргүйгээр, 20 хүртэлх хувийг өөрийн өртгөөр нь тооцож тусгай санд шилжүүлэх...” гэж заасан нь Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн асуудлаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсний дагуу өргөдлийн энэхүү хэсэгт хариу тайлбар бэлтгэлээ. Үүнд:



Монгол Улсын Засгийн газар нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага болохын хувьд Монгол Улсын Үндсэн хууль болон Засгийн газрын тухай хуулиар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Тухайлбал: Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д "... хүн амын бодлого, ... ахмадуудын талаар төрөөс явуулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх...", мөн зүйлийн 6-д "...иргэдийн ахуй, орон сууцны нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах" нь Засгийн газрын үндсэн бүрэн эрхэд хамаарахаар заасан байна.

Засгийн газрын 2007 оны 250 дугаар тогтоолын 3 дахь заалт нь улсаас орон сууц авч байгаагүй ахмад дайчид болон бага орлоготой иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, эдгээр иргэдийг орон сууцаар хангах зорилгоор орон сууцны фонд бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ юм.

Засгийн газар нь ахмад дайчдыг орон сууцтай болгох ажлын хүрээнд дээрх тогтоол болон "Дайнд оролцсон ахмад дайчинд орон сууц олгох тухай" Засгийн газрын 2009 оны 212 дугаар тогтоол, "Дайнд оролцсон ахмад настнуудын талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 170 дугаар зарлигийн дагуу 2011 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 1600 гаруй ахмад дайчдад орон сууцны дэмжлэг үзүүлээд байгаа болно." гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Засгийн газрын "Ахмад дайчдын орон сууцны тухай" 2007 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 250 дугаар тогтоолын 3 дахь заалтад "Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад орон сууц барих зориулалтаар газар олгох, гэрээ байгуулахдаа барих орон сууцны 2.0 хувийг үнэ төлбөргүйгээр, 20.0 хүртэл хувийг өөрийн өртгөөр нь тооцож тусгай санд шилжүүлэх..." гэж заасан нь Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Засгийн газрын "Ахмад дайчдын орон сууцны тухай" 2007 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 250 дугаар тогтоолын 3 дахь заалтад "Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад орон сууц барих зориулалтаар



газар олгох, гэрээ байгуулахдаа барих орон сууцны 2.0 хувийг үнэ төлбөргүйгээр, 20.0 хүртэл хувийг өөрийн өртгөөр нь тооцож тусгай санд шилжүүлэх..." гэж заасан нь Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах..." гэснийг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Н.ЖАНЦАН

ГИШҮҮД

П.ОЧИРБАТ

Д.НАРАНЧИМЭГ

Д.МӨНХГЭРЭЛ

Б.ПҮРЭВНЯМ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн редакци.

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас: 1.75

Индекс: 14003